



АРХАНГАЙ АЙМАГ
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 17 өдөр

Дугаар A/48

Эрдэнэбулган сум

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, 6.2 дахь заалт, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн “Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” А/162 дугаар тушаал, Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрмийн 1.5 дахь заалт, Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн санал, дүгнэлт, Төвийн даргын дэргэдэх зөвлөлийн 2025 оны 16, 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Ерөнхий технологич инженер бөгөөд багаж хэмжилзүй хариуцсан технологич инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Цаг уурын технологич инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Хөдөө аж ахуйн цаг уурын технологич инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Урьдчилан мэдээлэхийн технологич инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Урьдчилан мэдээлэхийн инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Холбоо сүлжээний ерөнхий инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Цаг агаарт зориудаар нөлөөлөхийн ерөнхий инженер бөгөөд мэдээллийн сангийн ерөнхий зохицуулагчийн албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Байгаль орчны шинжилгээний лабораторийн инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Ус судлалын технологич инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Цаг уур, хөдөө аж ахуйн цаг уурын ахлах техникч, инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Өртөөний ахлах техникч, инженерийн албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Цаг уурын өртөөний техникчийн албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Хөдөө аж ахуйн цаг уурын харуулын техникчийн албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Усны харуулын ажиглагчийн албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Хүний нөөц, бичиг хэрэг хэргийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Нярав,

652501205

байгууллагын архивын ажилтаны албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар, Цаг агаарт зориудаар нөлөөлөхийн техникч, жолоочийн албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Сантехникийн слесайн албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Үйлчлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий технологич инженер бөгөөд багаж хэмжилзүй хариуцсан технологич инженер (Д.Их-Оюун), Ерөнхий нягтлан бодогч (Г.Гэрэлмаа), Хүний нөөц, бичиг хэргийн эрхлэгч (Д.Гантуул) нарт тус тус үүрэг болгосугай.


3.Баталсан албан тушаалын тодорхойлолтыг холбогдох албан хаагчдад албан ёсоор танилцуулж, танилцсан тухай баримтад гарын үсэг зуруулж, хувийн хэрэгт нь хавсаргахыг үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БУЛГАНБААТАР

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний
төвийн даргын 2025 оны 11 дугаар сарын 17 -ны
өдрийн А/48 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:

"Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн
дүрэм, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Цаг уур,
орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар
сарын 04-ний А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо: 2025 оны 09 дүгээр сарын 19

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

2025 оны 11 дүгээр сарын 17

Байгууллагын нэр:

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны
шинжилгээний төв

Албан тушаалын нэр:

Ерөнхий технологич инженер бөгөөд багаж
хэмжил зүй хариуцсан технологич инженер
Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжлийн, ТҮМ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Архангай аймгийн Эрдэнэбулган сум, 7-р баг,
Хөгжлийн гудамж, 105 тоот

Онцгой нөхцөл:

Албан томилолтоор ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлыг төлөвлөх, уялдуулж зохицуулах,
зохион байгуулах, хяналт тавьж мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах,
зааварлах, тасралтгүй хэвийн ажиллагаа, багаж хэмжилзүйн нэгдмэл байдлыг хангах, технологийг
мөрдүүлж гүйцэтгэлийн үр дүнг төвийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг төлөвлөх, уялдуулж зохицуулах,
хөтөлбөрийн хэрэгжилт болон салбар нэгжийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах ажлыг
зохион байгуулж, хяналт тавих, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар
хангах, мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх
- Ус цаг уур, орчны шинжилгээний салбар, нэгжүүдийн технологи, стандартыг мөрдүүлэх,
техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх, хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах,
механик болон автомат хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаанд үзлэг үйлчилгээ хийж, цаг
уурын автомат станцуудыг шинээр суурилуулах ажлыг зохион байгуулах, шалган зааварлах;
- Хөтөлбөрт ажлын технологийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжийн
судалгааг гаргаж захиалах, шийдвэрлүүлэх;
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд:	1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж, газрын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангах, үндэсний хөтөлбөр, төсөл, бодлогын баримт бичгүүдэд саналыг нэгтгэн боловсруулах, тайлагнах, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулах, үр дүнг нэгтгэн тайлагнах;	Хуулийн хэрэгжилт хангагдана.	Г,Х,Ш
	2.Ус цаг уур, орчны төлөв байдлын өөрчлөлт, агаар, хөрс, ус, цацрагийн идэвхийн түвшний хяналт шинжилгээний үр дүнгээр дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, шаардлага тавих, үүрэг даалгавар өгөх, гарсан зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцох;	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г,Х,Ш
	3.Ус цаг уур, орчны шинжилгээний салбаруудын хөтөлбөрт ажлын хэрэгжилтийг хангуулах, технологич инженер, инженерүүдийн ажлыг уялдуулан зохицуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;	Хөтөлбөр бүрэн хийгдсэн байна. Ажлын уялдааг хангасан байна.	Т,Х,Г,Ш
	4.Хариуцсан ажил болон төвийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайлан, дүгнэлт, судалгааг удирдах дээд байгууллага, холбогдох албан тушаалтан болон байгууллагад гаргаж өгөх;	Хамтран ажилласан байна.	Г,Х,Ш
	5.Шууд харьяалан удирдуулах албан хаагчдыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, батлуулах шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний өдөр тутмын ажилд хяналт тавих, шалган зааварлах, үүрэг даалгавар өгөх, үр дүнг үнэлэх, түүнд сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах талаар санал, дүгнэлт гаргах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г,Х,Ш
	6.Мэргэжлийн хүний нөөцийг тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах, мэргэжил, мэдлэгийг нь дээшлүүлэх, ажиллагсдын ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, санал боловсруулах;	Ажиллагсдын нийгмийн баталгаа хангагдана.	Г,Х,Ш
	7.Зохих журмын дагуу боловсруулсан төсөл буюу удирдах дээд байгууллагаас өгсөн үүргийн дагуу эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлыг хийх, холбогдох албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах;	Шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г,Х,Т,Ш
	8.Ус, цаг уурын өртөө, харуул, урьдчилан мэдээлэхийн ажлын цагийн хуваарийг тухайн сар эхлэхээс өмнө 48 цагаас доошгүй хугацааны өмнө хүлээн авч хянаж, батлуулсан байх;	Хуваарийг хугацаанд нь хянаж батлуулсан байна.	Г,Х,Ш

	9.Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын тасралтгүй хэвийн ажиллагааг хангахад шаардагдах төсөв, санхүүг тооцоолон санал оруулах, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;	Шинжилгээний ажлын тасралтгүй хэвийн ажиллагааг хангагдана.	Г,Х,Ш
	10.Хариуцсан ажлын чиглэлээр захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл лавлагааны баримт бичгийн төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирна.	Г,Х,Ш
	11.Байгууллагын удирдлагад ус цаг уур, орчны шинжилгээ судалгаа, мэдээлэл үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, холбогдох мэдээллээр хангах;	Зөвлөгөө, дэмжлэг үзүүлж холбогдох мэдээллээр шуурхай хангасан байна.	Г
	12. Арга зүй, технологи, багаж хэмжилзүй, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн хариуцах, холбогдох албан тушаалтан, байгууллага иргэдэд зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хамтарч ажиллах, мэдээллийн эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн хүрээг өргөтгөх, хариуцсан салбарын ажлаа сурталчлах;	Тодорхой арга хэмжээг зохион байгуулсан байна.	Т, Х,Г,Ш
	13. Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын дүнг байгууллагын хэмжээнд нэгтгэн гаргаж, даргад танилцуулах;	Дүнг нэгтгэн гаргаж, танилцуулсан байна.	Х,Г
2 дугаар зорилтын хүрээнд:	1.Тухайн жилд хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулах график төлөвлөгөө гарган Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори болон төвийн даргаар батлуулан мөрдөж ажиллах;	График, төлөвлөгөө хэрэгжсэн байна.	Г
	2. Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажилд ашиглагдаж байгаа багаж, хэмжих хэрэгслийн нарийвчилсан судалгааг гарган тухай бүрт баяжилт хийх, тухайн жилд шаардлагатай байгаа багаж хэмжих хэрэгслийн захиалгыг нэгтгэн удирдах дээд байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх;	Хөтөлбөрт ажил биелэгдсэн байх	Г,Х,Ш
	3. Ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажилд ашиглагдаж байгаа багаж, хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн баталгаажуулах, хэвийн ажиллагааг хангаж ажиллах;	Багажийн гэмтэл саатал арилсан байна.	Г,Т,Ш
	4.Автомат станцуудын программ хангамжинд шинэчлэл хийсэн тухай бүрд тавил тохируулгыг шинэчлэн хийх, техникчдэд заавар зөвлөмж өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;	Өртөө, харуулд заавар зөвлөмж өгсөн байна.	Г
	5.Өртөө, харуулд шинээр суурилуулах автомат станцуудыг угсарч суурилуулах ажлыг гүйцэтгэж, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх;	Шинэ автомат станцаар хангагдахад суурилуулсан байна.	Г
	6.Тухайн жилийн шалган туслах ажлын болон хэмжих хэрэгсэлийн үзлэг шалгалт, баталгаажуулах төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх, тайлан мэдээг гаргаж холбогдох газарт хүргүүлэх;	Хэмжих хэрэгсэлд үзлэг үйлчилгээ хийгдсэн байна.	Г

	7.Хэмжлийн технологи, заавар, стандартыг мөрдүүлэх;	Заавар стандарт мөрдөгдсөн байна	Г,Х
	8.Салбарын технологийн баримт бичиг, стандарт, заавар, журмыг мөрдүүлэх, байнгын хяналт тавьж, өдөр тутмын арга зүйн удирдлагаар хангах.	Хэмжих хэрэгсэл, хэмжлийн технологи гэрчилгээжиж, баталгаажсан байна.	Х,Ш
	9.Салбарын сургалтыг Цаг уур, орчны шинжилгээний газрын сургалт, семинар, мэргэжлийн хичээлийн нэгдсэн төлөвлөгөө, графикт санал оруулах, мөрдөх, зайны сургалт явуулах;	Сургалтад хамруулсан байна.	Г,Х,Ш
3 дугаар зорилтын хүрээнд:	1. Шинжилгээний ажлын хөтөлбөрийг үндэслэн шаардлагатай багаж, төхөөрөмж, сэлбэг материалыг төвлөрсөн хангамжаас захиалан авах, хуваарилах, ашиглалт, зарцуулалтад нь хяналт тавих, хэмжих хэрэгслийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтоосон хугацаанд хийлгэх, шалгалт сорилын баталгаажуулалтад оруулж хэмжлийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангах;	Багаж, хэмжих хэрэгслэл хангасан байна. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулсан байна.	Х,Г,Ш
	2.Шинжилгээний ажилд тэнцэхгүй болсон болон актлах шаардлагатай багаж хэмжих хэрэгслийг Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторит хүргүүлж мэдэгдэл гаргуулах;	Шаардлагатай арга хэмжээг авсан байна.	Х,Г,Ш
4 дүгээр зорилтын хүрээнд:	1.Шууд удирдлага болон байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, ажлын хэсэгт ажиллах, үр дүнг тайлагнах; шаардлагатай мэдээллээр хангах;	Өгсөн үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэж, тайлагнасан байна. Ажлын хэсэгт идэвх, санаачилгатай ажилласан байна.	Г
	2.Баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн журам, стандартын дагуу (хос бичгээр баримт хөтлөх) боловсруулах, өмнөх оны шийдвэрлэгдсэн баримтаар хэрэг бүрдүүлж хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж, дараа оны 1-р улиралд багтаан хадгаламжийн нэгж үүсгэн архивын ажилтанд хүлээлгэн өгөх;	Баримт бичгийг холбогдох журам, стандартын дагуу боловсруулж бүрдүүлсэн байна. Архивт хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн байна.	Г
	3.Хариуцсан ажлын чиглэлээр иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хариу өгөх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	4.Монгол Улсын стандарт "Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага"-ыг үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх;	Стандартыг мөрдсөн байна.	Г
	5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г
	6.Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйл, орчны ноцтой бохирдол үүссэн тохиолдолд тусгай горимд шилжин ажиллах;	Шаардлагатай тохиолдолд ажилласан байна.	Г,Т,Ш
	7.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд байгууллагын даргын зөвшөөрснөөр бусад	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г

	байгууллага, иргэдтэй байгууллагыг төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;		
	8.Хариуцсан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлыг зохистой ашиглах, бүрэн бүтэн байдлыг хангах, хүлээлцдэг байх, хяналт тавих;	Холбогдох журам, стандартыг мөрдсөн байна.	Г,Х,Ш
	9. Ажилдаа шинэ арга зүй, техник технологийг турших, нэвтрүүлэх талаар санал гаргах	Шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г
	10. Эрхэлсэн ажилтай холбоотой хууль тогтоомж болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна.	Г
	11.Байгууллагаас зохион байгуулах ажилд манлайлан оролцох, сарын ажлыг хариуцан зохион байгуулж, салбарын ажилд хяналт тавьж зохицуулах.	Зохион байгуулж, манлайлж ажилласан байна.	Г
	12. Байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцох;	Идэвхтэй оролцсон байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол		Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
Мэргэжил		-Цаг уур судлал (053210) -Уур амьсгал судлал (053212)
Мэргэшил		-Цаг уурын багаж хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх эрхийн үнэмлэхтэй байх; -Ус, цаг уурын багаж, хэмжилзүйн чиглэлээр мэргэшсэн байх;
Туршлага		-Цаг уурын мэргэжлээр 3-аас доошгүй жил ажилласан байх;
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах; -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах чадвартай;
	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон харьцуулсан шинжилгээ хийх, судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын үр дагаварыг харьцуулан үнэлэх; -шинэ санал санаачилга, бүтээлч хандлагатай байх; -албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;
	Асуудал шийдвэрлэх	-Асуудлын учир шалтгааныг зөв тодорхойлж, шийдвэрлэх оновчтой хувилбарыг тогтоох; -Чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид нийцсэн, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; -Хууль тогтоомжийг даган мөрдөж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
	Багаар ажиллах	-Төрийн албаны ёс зүйг баримтлах; -Хариуцлагатай, санаачилгатай, нээлттэй байж эерэг уур амьсгалыг дэмждэг байх; -Багт өөрийн гүйцэтгэх үүргээ тодорхойлж, хариуцлагатай, санаачилгатай хамтрагч байх;
	Бусад	-Өөрийн санал, бодлыг бусдад ойлгомжтой илэрхийлэх. -Компьютерийн хэрэглээний програмууд болон хариуцсан ажлын чиглэлээр ашиглагдаж байгаа программ (ArcGis, бусад), техник хэрэгсэл (принтер, сканер, ухаалаг самбар, таблет, видео камер г.м)-ийг бүрэн эзэмшсэн байх; -Мэдээллийн технологи, цахим орчин, мэдээллийн системүүдийг ашиглах; -Төрийн албан хэрэг хөтлөх болон монгол бичиг, найруулга зүйн чадвартай байх; -Орлон, хөрвөж ажиллах; -Англи хэлний дунд болон түүнээс дээш шатны мэдлэгтэй байх;

- Ажлын цагийг баримтлаж, үр бүтээлтэй ашиглах;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ харилцах субъект

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

1. Төвийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Технологич инженерүүд-7

Бусад харилцах субъект:

-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Цаг уур, орчны шинжилгээний газрын холбогдох мэргэжилтэн
-Байгууллагын нийт удирдах, гүйцэтгэх, туслах ажилтан, албан хаагчид
-Төрийн бусад байгууллага, тэдгээрийн холбогдох мэргэжилтэн
-Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,
ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ

Д.ГАНТУУЛ

Д.ГАНТУУЛ

Байгууллагын нэр:

Шийдвэрийн огноо:

Дугаар:

2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв

Шийдвэрийн огноо:2025. 11.17

Дугаар:

A/48

(тамга/тэмдэг)

ДАРГА

(гарын үсэг)

Б.БУЛГАНБААТАР

Б.БУЛГАНБААТАР

(эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний
төвийн даргын 2025 оны 11 дугаар сарын 17-ны
өдрийн 1148 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:

"Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн
дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" Цаг уур,
орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар
сарын 04-ний өдрийн А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо: 2025 оны 09 дүгээр сарын 19

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

2025 оны 11 дүгээр сарын 17

Байгууллагын нэр:

Архангай аймгийн Ус, Цаг уур, орчны
шинжилгээний төв

Албан тушаалын нэр:

Цаг уурын технологич инженер

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжлийн, ТҮМ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Архангай аймгийн Эрдэнэбулган сум, 7-р баг,
Хөгжлийн гудамж-105

Онцгой нөхцөл:

Албан томилолтоор ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цаг уурын хяналт шинжилгээ, судалгаа, мэдээлэл, үйлчилгээний ажлыг батлагдсан хөтөлбөрийн тасралтгүй ажиллагааг хангах, шинжилгээний ажлын технологи мөрдөлтийг хангуулж, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангах, эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажил хийж уур амьсгалын горим, нөөцийг тогтоох ажлыг хариуцаж, гүйцэтгэлийн үр дүнг төвийн дарга болон ерөнхий технологич инженерийн өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Улсын сүлжээний цаг уурын судалгаатай холбоотой бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, цаг уурын хяналт шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, техник, технологийн арга зүйн шинэчлэлийг нэвтрүүлэх, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах, хяналт тавих;
- Салбарын хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулж, технологийг мөрдүүлэх, ажиглалт, хэмжлийн үр дүн хэмжлийн технологид нийцэж буйг хянан шалгаж, үнэлэх, үл тохирлыг арилгах, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, мэргэжлийн чиглэлээр албан хаагчдыг чадавхжуулах, шалган туслах;
- Эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажил хийх, уур амьсгалын горим, нөөцийг тогтоох;
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд:	1.Цаг уур, нарны цацраг судлалын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, шууд харьяалан удирдуулах албан хаагчдыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, батлуулах шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний өдөр тутмын ажилд хяналт тавих, шалган зааварлах, үүрэг даалгавар өгөх, үр дүнг үнэлэх, түүнд сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах талаар санал, дүгнэлт гаргах;	Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Хууль тогтоомжид нийцсэн байна.	Т,Х,Г,Ш
	2.Цаг уурын хяналт шинжилгээний ажлын нэгдсэн хөтөлбөрийн хүрээ, цаашдын зорилт арга хэмжээг тодорхойлох, санал өгөх;	Зорилт, арга хэмжээнд санал өгсөн байна.	Г
	3. Ажилдаа шинэ арга зүй, техник технологийг турших, нэвтрүүлэх талаар санал боловсруулах;	Санал боловсруулж өгсөн байна.	Г
	4.Хариуцсан ажилтай холбоотой судалгаа, шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний болон өртөө, харуулын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайлан, дүгнэлт, судалгааг удирдах дээд байгууллага, холбогдох албан тушаалтан болон байгууллагад гаргаж өгөх;	Технологийн зөрчилгүй мэдээ, тайлан гарсан байна.	Г,Х,Ш
	5.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд удирдлага болон бусад албан хаагчдад мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх;	Мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна.	Т, Г
	6.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд байгууллагын даргын зөвшөөрснөөр бусад байгууллага, иргэдтэй байгууллагыг төлөөлөн гэрээ хэлцэл хийх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	7.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд Үндэсний хөтөлбөр, төсөл, бодлогын баримт бичиг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслүүдэд саналыг боловсруулах, хэрэгжилтийг ханган тайлагнах;	Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэсэн байна.	Г
	8.Судалгаа шинжилгээний ажлын жилийн цаасан болон цахим материалыг архивлан төрөлжсөн архивт хүлээлгэн өгөх;	Архивт хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн байна.	Г,Х,Ш
	9.Байгууллагын бусад инженерүүдтэй ажлаа уялдуулан зохицуулах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах;	Бусад салбартай ажлаа уялдуулж хамтын ажиллагааг хэрэгжүүлсэн байна.	Т, Х, Г,Ш
2 дугаар Зорилтын хүрээнд:	1.Цаг уурын хяналт шинжилгээний ажлын технологийн заавар, журам, дүрмийг мөрдүүлэх, үл тохирлыг нягтлан шалгаж үнэлэх, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, арга зүйн удирдлагаар хангах;	Шинжилгээний ажлын чанар сайжирна.	Т,Г,Х,Ш

	2.Тухайн жилийн шалган туслах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлан мэдээг гаргаж холбогдох газарт хүргүүлэх; (төлөвлөгөөт, гэнэтийн, цаг үеийн)	Ажиглалтын чанар дээшилж алдаа зөрчил багассан байна.	Г,Х,Ш
	3.Салбарын сургалтыг Цаг уур, орчны шинжилгээний газрын сургалт, семинар, мэргэжлийн хичээлийн нэгдсэн төлөвлөгөө, графикт санал оруулах, мөрдөх, зайны сургалт явуулах;	Сургалтад хамруулсан байна.	Г,Х,Ш
	4.Цаг уурын өртөө, харуулын инженер, техникчдийг мэргэшүүлэх, шинээр (түр) орж буй ажилтныг дадлагажуулах, мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгуулах;	Сургалт зохион байгуулсан байна.	Г,Х
	5.Албан хаагчдыг мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтын захиалгыг байгууллагын сургалтын төлөвлөгөө, төсвийн төсөлд санал оруулж, баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Сургалтад хамрагдаж мэргэшсэн байна.	Г,Т
	6.Өртөө, харуулуудын ажиглалт, шинжилгээний материалд шүүмж шалгалт хийж баталгаажуулах, хариу зааварчилгаа өгөх, шалган зааварлах, шинжилгээний материалаар зохих журмын дагуу мэдээллийн архив, цахим сан бүрдүүлэх;	Үнэн зөв цахим болон цаасан мэдээллийн сан үүссэн байна. Шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	Г,Х,Ш
	7. Шинжилгээний ажлын хөтөлбөрийг үндэслэн шаардлагатай багаж, төхөөрөмж, сэлбэг материалын захиалгыг өгөх, хяналт тавих, хэмжих хэрэгслийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтоосон хугацаанд хийлгэх;	Тасралтгүй ажиллагаа хангагдсан байна.	Г,Т, Х
3 дугаар зорилтын хүрээнд:	1.Сар улирал, жилийн уур амьсгалын тойм бичих, Цаг уурын статистик мэдээг сар бүр гаргаж байгууллага, иргэдэд үйлчлэх;	Холбогдох цахим хуудсанд байршуулах, мэдээллээр хэрэглэгчдэд түргэн шуурхай үйлчилсэн байна.	Г
	2.Цаг уурын судалгаа шинжилгээний зүй тогтол, горимыг тогтоох, судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, холбогдох албан тушаалтан, байгууллага иргэдэд зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хамтарч ажиллах, мэдээллийн эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн хүрээг өргөтгөх, хариуцсан салбарын ажлаа сурталчлах;	Тодорхой арга хэмжээг зохион байгуулсан байна.	Т, Х,Г,Ш
	3.Хариуцсан ажилтай холбоотой мэдээ, тайлан, дүгнэлт, судалгааг холбогдох албан тушаалтан болон байгууллагад гаргаж өгөх, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, шаардлага тавьж, хэрэгжилтэд нь хяналт тавих;	Шаардлагатай ажлыг гүйцэтгэсэн байна.	Х, Т, Г, Ш
	4.Судалгааны сэдэв, зорилттой ажиллах, цаг уур, уур амьсгалын зүй тогтол, горимыг тогтоох, судалгаа, шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, илтгэл бэлдэх;	Судалгаа, шинжилгээ хийгдэж, илтгэлд бэлдсэн байна.	Г,Х,Ш
	5.Зохих журмын дагуу боловсруулсан төсөл болон удирдах дээд байгууллагаас өгсөн үүргийн дагуу эрдэм шинжилгээ, судалгаа туршилтын ажил хийх;	Шинжилгээ, судалгаа туршилтын ажил хийгдсэн байна.	Г

	6.Цаг уурын гамшигт үзэгдэл, түүнээс учирсан хохирлын тухай албан ёсны тодорхойлолт, тооцоо судалгааг холбогдох газар (сум, багийн Засаг дарга нар)-аас гаргуулан авах, дүн шинжилгээ хийх, мэдээлэх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Х,Г
4 дүгээр зорилтын хүрээнд:	1.Шууд удирдлага болон байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, ажлын хэсэгт ажиллах, үр дүнг тайлагнах; шаардлагатай мэдээллээр хангах;	Өгсөн үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэж, тайлагнасан байна байна. Ажлын хэсэгт идэвх, санаачилгатай ажилласан байна.	Г
	2. Цаг уурын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын дүнг ерөнхий технологич инженерт гаргаж өгөх;	Дүнг хугацаанд нь гаргаж өгсөн байна.	Т,Х,Г
	3.Баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн журам, стандартын дагуу (хос бичгээр баримт хөтлөх) боловсруулах, өмнөх оны шийдвэрлэгдсэн баримтаар хэрэг бүрдүүлж хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж, дараа оны 1-р улиралд багтаан хадгаламжийн нэгж үүсгэн архивын ажилтанд хүлээлгэн өгөх;	Баримт бичгийг холбогдох журам, стандартын дагуу боловсруулж бүрдүүлсэн байна. Архивт хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн байна.	Г
	4.Хариуцсан ажлын чиглэлээр иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хариу өгөх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Ш
	5.Монгол Улсын стандарт "Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага"-ыг үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх;	Стандартыг мөрдсөн байна.	Т, Х, Г
	6.Байгууллагын дэвшүүлсэн зорилтын хүрээнд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Холбогдох журам, стандартыг хэрэгжүүлсэн байна.	Г
	7.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийг мөрдсөн байна.	Т, Х, Г
	8.Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах, хэрэгжилт хариуцах;	Хамааралтай заалтуудыг хэрэгжүүлсэн байна.	Г,Х,Ш
	9.Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйл, орчны ноцтой бохирдол үүссэн тохиолдолд тусгай горимд шилжин ажиллах;	Шаардлагатай тохиолдолд ажилласан байна.	Г,Т
	10.Хариуцсан ажлын чиглэлээр захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл лавлагааны баримт бичгийн төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулах;	Холбогдох журам, стандартыг мөрдсөн байна.	Г
	11.Хариуцсан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлыг зохистой ашиглах, бүрэн бүтэн байдлыг хангах, хүлээлцдэг байх;	Холбогдох журам,	Г

		стандартыг мөрдсөн байна.	
	12. Эрхэлсэн ажилтай холбоотой хууль тогтоомж болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна.	Г
	13. Байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцох;	Идэвхтэй оролцсон байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол		-Бакалавр ба түүнээс дээш боловсролтой байх.
Мэргэжил		-Цаг уур судлал (053210), Уур амьсгал судлал (053212)
Мэргэшил		Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх;
Туршлага		Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан бол давуу байна.
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах; - Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдан чиглүүлэх;
	Дүн шинжилгээ хийх	- Мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон харьцуулсан шинжилгээ хийх, судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын үр дагаварыг харьцуулан үнэлэх; - шинэ санал санаачилга, бүтээлч хандлагатай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;
	Асуудал шийдвэрлэх	- Асуудлын учир шалтгааныг зөв тодорхойлж, шийдвэрлэх оновчтой хувилбарыг тогтоох; - Чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид нийцсэн, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; - Хууль тогтоомжийг даган мөрдөж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
	Багаар ажиллах	- Төрийн албаны ёс зүйг баримтлах; - Хариуцлагатай, санаачилгатай, нээлттэй байж эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Багт өөрийн гүйцэтгэх үүргээ тодорхойлж, хариуцлагатай, санаачилгатай хамтрагч байх;
	Бусад	-Өөрийн санал, бодлыг бусад ойлгомжтой илэрхийлэх; -Компьютерийн хэрэглээний болон хариуцсан ажлын чиглэлээр ашиглагдаж байгаа программ (ArcGis, бусад), техник хэрэгсэл (принтер, сканнер, ухаалаг самбар, таблет, видео камер г.м)-ийг бүрэн эзэмшсэн байх; -Мэдээллийн технологи, цахим орчин, мэдээллийн системүүдийг ашиглах; -Төрийн албан хэрэг хөтлөх болон монгол бичиг, найруулга зүйн чадвартай байх; -Орлон хөрвөж ажиллах; -Англи хэлний анхан болон түүнээс дээш шатны мэдлэгтэй байх; -Ажлын цагийг баримтлаж, үр бүтээлтэй ашиглах;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Ерөнхий технологич инженер

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-Цаг уур, хөдөө аж ахуйн цаг уурын ахлах техникч, инженер-1, ертөөдийн ахлах техникч, инженер-4, харуулын


Бусад харилцах субъект:

1.Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллага, хэлтсүүд, холбогдох мэргэжилтэн
2.Байгууллагын нийт удирдах, гүйцэтгэх, туслах ажилтан, албан хаагчид

техникчид-13 Нийт 18	3.Төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн холбогдох мэргэжилтэн 4.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага
-------------------------	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаал:</u> АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ <i>Д.ГАНТУУЛ</i> 2025 оны <i>11</i> дугаар сарын <i>17</i> -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: <u>Байгууллагын нэр:</u> АРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ <u>Шийдвэрийн огноо:</u> <i>2025. 11. 17</i> <u>Дугаар:</u> <i>1148</i> ДАРГА <i>Б.ВУЛГАНБААТАР</i> 2025 оны <i>11</i> дугаар сарын <i>17</i> -ны өдөр	

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний
төвийн даргын 2025 оны . 11 дугаар сарын .17 -ны
өдрийн 1118 дугаар тушаалын .3 . дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:

“Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025 оны 09 дүгээр сарын 19

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

2025 оны 11 дүгээр сарын 17

Байгууллагын нэр:

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны
шинжилгээний төв

Албан тушаалын нэр:

Хөдөө аж ахуйн цаг уурын технологич
инженер

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжлийн, ТҮМ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 7-р баг,
Хөгжлийн гудамж 105 тоот

Онцгой нөхцөл:

Албан томилолтоор ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөдөө аж ахуйн цаг уурын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлыг батлагдсан хөтөлбөрийн тасралтгүй ажиллагааг хангах, шинжилгээний ажлын технологи мөрдөлтийг хангуулж, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, арга зүйн удирдлага, зөвлөмжөөр хангах, хөдөө аж ахуйн цаг уурын мэдээгээр үйлчилгээ үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хариуцаж, гүйцэтгэлийн үр дүнг төвийн дарга болон ерөнхий технологич инженерийн өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Хөдөө аж ахуйн цаг уур, мэдээлэл үйлчилгээний судалгаатай холбоотой бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, цаг уурын хяналт шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах, хяналт тавих;

2. Салбарын хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулж, технологийг мөрдүүлэх, ажиглалт, хэмжлийн үр дүн хэмжлийн технологид нийцэж буйг хянан шалгаж, үнэлэх, үл тохирлыг арилгах, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, мэргэжлийн чиглэлээр албан хаагчдыг чадавхжуулах, шалган туслах;

3. Хөдөө аж ахуйн цаг уурын чиглэлээр судалгааны ажил хийх, бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай, урьдчилсан мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэх;

4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн	Хариуцлага
--------	------------------------------------	--------------	------------

		шалгуур үзүүлэлт	оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд:	1.Хөдөө аж ахуйн цаг уурын хяналт шинжилгээний ажлын батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, өртөө, харуулын ажилд тогтмол хяналт тавих, ажлыг нь шалган зааварлах, дотоод хяналтыг хийх мэргэжил арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах, ажлын үр дүнг үнэлэх, түүнд сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах талаар санал дүгнэлт гаргах;	Хөтөлбөр бүрэн хэрэгжсэн байна. Хууль тогтоомжийг мөрдсөн байна.	Т,Х,Г,Ш
	2. Хөдөө аж ахуйн цаг уурын хяналт шинжилгээний ажлын нэгдсэн хөтөлбөрийн хүрээ, цаашдын зорилт арга хэмжээг тодорхойлох, санал өгөх;	Зорилт, арга хэмжээнд санал өгсөн байна.	Г
	3.Ажилдаа шинэ арга зүй, техник технологийг турших, нэвтрүүлэх талаар санал боловсруулах;	Санал боловсруулж өгсөн байна.	Г
	4.Хариуцсан ажилтай холбоотой судалгаа, шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний мэдээ, тайлан, дүгнэлт, судалгааг удирдах дээд байгууллага, холбогдох албан тушаалтан болон байгууллагад гаргаж өгөх;	Технологийн зерчилгүй мэдээ, тайлан гарсан байна.	Г,Х,Ш
	5.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд удирдлага болон бусад албан хаагчдад мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	Мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна.	Т, Г
	6.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд байгууллагын даргын зөвшөөрснөөр бусад байгууллага, иргэдтэй байгууллагыг төлөөлөн гэрээ хэлцэл хийх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	7.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд Үндэсний хөтөлбөр, төсөл, бодлогын баримт бичиг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслүүдэд саналыг боловсруулах, хэрэгжилтийг ханган тайлагнах;	Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэсэн байна.	Г
	8.Харуулын ажлын цагийн хуваарийг тухайн сар эхлэхээс өмнө 48 цагаас багагүй хугацааны өмнө боловсруулж, хянуулж, батлуулан, ажлын цагийн тооцоог хүснэгтийн дагуу гаргаж, холбогдох материалын хамт сар бүр санхүүд хүлээлгэн өгөх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г,Х,Ш
	9.Байгууллагын бусад инженерүүдтэй ажлаа уялдуулан зохицуулах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах;	Бусад салбартай ажлаа уялдуулж хамтын ажиллагааг хэрэгжүүлсэн байна.	Т,Г,Х,Ш
	10.Судалгаа шинжилгээний ажлын жилийн цаасан болон цахим материалыг архивлан төрөлжсөн архивт хүлээлгэн өгөх;	Архивын цаасан сан бүрдсэн байна.	Г,Х,Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хөдөө аж ахуйн цаг уурын хяналт шинжилгээний ажлын технологийн заавар, журам, дүрмийг мөрдүүлэх, үл тохирлыг нягтлан шалгаж үнэлэх, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, арга зүйн	Шинжилгээний ажлын чанар сайжирна.	Т,Г,Х,Ш

	удирдлагаар хангах;		
	2.Ихтамир сумын нутгаар гүйцэтгэх, өвөл, зуны бэлчээрийн төлөв байдлын явуул судалгаа, цаг үе хүндэрсэн нөхцөлд явуул судалгааг хийх, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, арга зүйн удирдлагаар хангах;	Хөтөлбөрт ажил бүрэн хийгдсэн байна.	Г,Х,Ш,Т
	3.Тухайн жилийн шалган туслах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлан мэдээг гаргаж холбогдох газарт хүргүүлэх; (төлөвлөгөөт, гэнэтийн, цаг үеийн)	Ажиглалтын чанар дээшилж алдаа зөрчил багассан байна.	Г,Х,Ш
	4.Салбарын сургалтыг Цаг уур, орчны шинжилгээний газрын сургалт, семинар, мэргэжлийн хичээлийн нэгдсэн төлөвлөгөө, графикт санал оруулах, мөрдөх, зайны сургалт явуулах;	Сургалтад хамруулсан байна.	Г,Х,Ш
	5.Цаг уурын өртөө, харуулын инженер, техникчдийг мэргэшүүлэх, шинээр (түр) орж буй ажилтныг дадлагажуулах, мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгуулах;	Сургалт зохион байгуулсан байна.	Г,Х
	6.Албан хаагчдыг мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтын захиалгыг байгууллагын сургалтын төлөвлөгөө, төсвийн төсөлд санал оруулж, баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Сургалтад хамрагдаж мэргэшсэн байна.	Г,Т
	7.Өртөө, харуулуудын ажиглалт, шинжилгээний материалд шүүмж шалгалт хийж баталгаажуулах, хариу зааварчилгаа өгөх, шинжилгээний материалаар зохих журмын дагуу мэдээллийн архив, цахим сан бүрдүүлэх;	Үнэн зөв цахим болон цаасан мэдээллийн сан үүссэн байна.	Г,Х
	8. Шинжилгээний ажлын хөтөлбөрийг үндэслэн шаардлагатай багаж, төхөөрөмж, сэлбэг материалын захиалгыг өгөх, хяналт тавих, хэмжих хэрэгслийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтоосон хугацаанд хийлгэх;	Тасралтгүй ажиллагаа хангагдсан байна.	Г,Т, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хөдөө аж ахуйн цаг уурын мэдээлэл үйлчилгээний ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, арга зүйгээр хангах, мэдээ, мэдээллээр үйлчлэх;	Мэдээллээр үйлчилсэн байна.	Т,Г,Ш
	2.Орон нутгийн онцлог, горим, уур амьсгалын өөрчлөлт нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөг судлах;	Судалгааны сэдэв, үр дүнтэй байна.	Г
	3.Цаг үеийн хурал зөвлөгөөнд хариуцсан ажлын чиглэлээр мэдээлэл өгөх; (өвөлжилт, хаваржилт, зуншлага, ган, зуд, тариаланчдын зөвлөгөөн гэх мэт)	Мэдээллээр хангасан байна.	Г
	4.Орон нутгийн онцлогоор түүвэр судалгаа хийж үнэлэлт, дүгнэлт гаргах, илтгэл бэлдэх;	Түүвэр судалгаа хийж илтгэл бэлдсэн байна.	Г
	5.Хөдөө аж ахуйн цаг уурын чиглэлээр судалгаа шинжилгээний зүй тогтол, горимыг тогтоох, судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, холбогдох албан тушаалтан, байгууллага иргэдэд зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хамтарч ажиллах, мэдээллийн эрэлт хэрэгцээг судалсны үндсэн дээр төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн хүрээг өргөтгөх, хариуцсан салбарын ажлаа сурталчлах;	Тодорхой арга хэмжээг зохион байгуулсан байна.	Т, Х,Г,Ш

	6.Хариуцсан судалгаа шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажилтай холбоотой дүгнэлт, судалгааг холбогдох албан тушаалтан болон байгууллагад гаргаж өгөх, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, шаардлага тавьж, хэрэгжилтэд нь хяналт тавих;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Х, Т, Г, Ш
	7.Судалгааны сэдэв, зорилттой ажиллах, цаг уур, уур амьсгалын зүй тогтол, горимыг тогтоох, судалгаа, шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, илтгэл бэлдэх;	Судалгааны сэдэв, үр дүнтэй, илтгэлд бэлдсэн байна.	Г,Х,Ш
	8.Зохих журмын дагуу боловсруулсан төсөл болон удирдах дээд байгууллагаас өгсөн үүргийн дагуу эрдэм шинжилгээ, судалгаа туршилтын ажил хийх;	Шинжилгээ, судалгаа туршилтын ажил хийгдсэн байна.	Г
	9.Хариуцсан ажлын чиглэлээр гамшигт үзэгдэл, түүнээс учирсан хохирлын тухай албан ёсны тодорхойлолт, тооцоо судалгааг холбогдох газар (сум, багийн Засаг дарга нар)-аас гаргуулан авах, дүн шинжилгээ хийх, мэдээлэх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Шууд удирдлага болон байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, ажлын хэсэгт ажиллах, үр дүнг тайлагнах, шаардлагатай мэдээллээр хангах;	Өгсөн үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэж, тайлагнасан байна. Ажлын хэсэгт идэвх, санаачилгатай ажилласан байна.	Г
	2.Баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн журам, стандартын дагуу (хос бичгээр баримт хөтлөх) боловсруулах, өмнөх оны шийдвэрлэгдсэн баримтаар хэрэг бүрдүүлж хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж, дараа оны 1-р улиралд багтаан хадгаламжийн нэгж үүсгэн архивын ажилтанд хүлээлгэн өгөх;	Баримт бичгийг холбогдох журам, стандартын дагуу боловсруулж бүрдүүлсэн байна. Архивт хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн байна.	Г
	3.Хариуцсан ажлын чиглэлээр иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хариу өгөх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Ш
	4.Монгол Улсын стандарт "Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага"-ыг үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх;	Стандартыг мөрдсөн байна.	Т, Х, Г
	5.Байгууллагын дэвшүүлсэн зорилтын хүрээнд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Холбогдох журам, стандартыг хэрэгжүүлсэн байна.	Г
	6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийг мөрдсөн байна.	Т, Х, Г
	7.Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйл, орчны нөцтой бохирдол үүссэн тохиолдолд тусгай горимд шилжин ажиллах;	Шаардлагатай тохиолдолд ажилласан байна.	Г,Т
	8.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тайлан гаргах;	Хамааралтай заалтуудыг хэрэгжүүлсэн байна.	Г,Х,Ш
	9.Хариуцсан ажлын чиглэлээр захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл лавлагааны баримт бичгийн төслийг хууль тогтоомжид нийцүүлэн	Холбогдох журам, стандартыг мөрдсөн байна.	Г

	боловсруулж, батлуулах;		
	10. Хариуцсан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлыг зохистой ашиглах, бүрэн бүтэн байдлыг хангах, хүлээлцдэг байх;	Холбогдох журам, стандартыг мөрдсөн байна.	Г
	11. Хөдөө аж ахуйн цаг уурын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын дүнг ерөнхий технологич инженерт гаргаж өгөх;	Дүнг хугацаанд нь гаргаж өгсөн байна.	Т,Х,Г
	12. Хариуцсан ажилтай холбоотой мэдээ, тайлан, дүгнэлт, судалгааг холбогдох албан тушаалтан болон байгууллагад гаргаж өгөх;	Шаардлагатай ажлыг гүйцэтгэсэн байна.	Г
	13. Эрхэлсэн ажилтай холбоотой хууль тогтоомж болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна.	Г
	14. Байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцох;	Идэвхтэй оролцсон байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	-Бакалавр ба түүнээс дээш боловсролтой байх.
Мэргэжил	-Цаг уур судлал (053210), Уур амьсгал судлал (053212)
Мэргэшил	Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх;
Туршлага	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан бол давуу байна.
Ур чадвар	Удирдан зохин байгуулах - Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах; - Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдан чиглүүлэх;
	Дүн шинжилгээ хийх -Мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон харьцуулсан шинжилгээ хийх, судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын үр дагаварыг харьцуулан үнэлэх; -шинэ санал санаачилга, бүтээлч хандлагатай байх; - Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;
	Асуудал шийдвэрлэх - Асуудлын учир шалтгааныг зөв тодорхойлж, шийдвэрлэх оновчтой хувилбарыг тогтоох; - Чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид нийцсэн, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; Хууль тогтоомжийг даган мөрдөж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
	Багаар ажиллах - Төрийн албаны ёс зүйг баримтлах; - Хариуцлагатай, санаачилгатай, нээлттэй байж эерэг уур амьсгалыг дэмждэг байх; -Багт өөрийн гүйцэтгэх үүргээ тодорхойлж, хариуцлагатай, санаачилгатай хамтрагч байх;
"Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025 оны 09 дүгээр сарын 19

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025 оны 11 дүгээр сарын 17

Байгууллагын нэр:

Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв

Албан тушаалын нэр:

Нярав, байгууллагын архивын ажилтан

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжлийн, ТҮМ-3

Ажлын байрны албан ёсны байршил:

Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 7-р баг, Хөгжлийн гудамж 105 тоот

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын өмч хөрөнгийг хамгаалах, бүртгэж тооцоолох, хэмнэлттэй зарцуулах, хяналт тавих, байгууллагын архивын үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу эрхлэн явуулж, гүйцэтгэлийн үр дүнг төвийн дарга болон ерөнхий нягтлан бодогчийн өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Нягтлан бодох бүртгэл, эд хөрөнгө, бараа материал, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Байгууллагын архивын цаасан болон цахим хадгаламжийн нэгжийг нөхөн бүрдүүлэх, хадгалалт хамгаалалтыг хариуцах, баримтаар албан хаагч, иргэдэд үйлчлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, харьяалах Төрийн архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Байгууллагын өмч хөрөнгийг хамгаалах, бүртгэж тооцоолох, хэмнэлттэй зарцуулах, хяналт тавих, ажлын байрны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээний чанарт хяналт тавих;
- Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны тооцоо бүртгэл хөтөлж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв гаргаж, ил тод шуурхай байдлыг хангах;
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г
--------	------------------------------------	-------------------------------	---

			Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Нягтлан бодох бүртгэл, эд хөрөнгө, бараа материал, архивын талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, тайлагнах;	Хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулагдсан байна.	Г
	2. Үндэсний хөтөлбөр, төсөл, бодлогын баримт бичиг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслүүдэд хариуцсан ажлын чиглэлээр саналыг боловсруулах, тайлагнах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	3. Байгууллагын аж ахуйн асуудлыг хариуцаж удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;	Үүрэг даалгавр биелсэн байна.	Г
	4. Архивын холбогдох хууль тогтоомж, стандартын талаар байгууллагын удирдлага болон албан хаагчдад аргазүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, мэдээ мэдээлэл бэлтгэх, сургалт хийх;	Шаардлагатай зөвлөгөө дэмжлэг үзүүлж мэдээллээр хангасан байна.	Г
	5. Байгууллагын архивын байнга хадгалах баримтыг цахимжуулж, санд оруулан нөөц болон ашиглалтын цахим хувь үүсгэх;	Цахимжуулсан баримтыг оны дарааллаар хавтас үүсгэн хадгалж, нөөц хувь үүсгэсэн байна.	Г
	6. Байгууллагын архивын цаасан баримт болон цахим баримтыг бүрдүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах;	Холбогдох зааврын дагуу ажилласан байна.	Г,Х
	7. Удирдлага болон албан хаагчдад эд хөрөнгө, бараа материал, архивын талаар зааварчилгааг өгөх, сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйгээр хангаж, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;	Зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, холбогдох мэдээллээр шуурхай хангасан байна.	Г,Т
2 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын архивын баримтын хадгалалт хамгаалалтын ажлыг зааврын дагуу хийж архивын баримтын өрөөний ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, гэрэл, дулаан, чийгийг хянан тохируулах, баримтад ариутгал, их цэвэрлэгээг хийлгэх, хадгалалтын нөхцөлийг хангаж ажиллах;	Байгууллагын архивын үндсэн зааврыг хэрэгжүүлсэн байна.	Г
	2. Хадгаламжийн нэгжийн дансыг батлуулах, байнга хадгалах баримтыг аймгийн харьяалах Төрийн архивын байнгын хадгалалтад шилжүүлэх ажлыг зохион байгуулах, хадгалах хугацаа дууссан баримтыг хэлэлцүүлж батлуулах, устгах ажлыг зохион байгуулах;	Данс бүртгэлийг хэвшсэн байна.	Г,Х,Т
	3. Хөтлөгдөж дууссан хэргийг журмын дагуу эмхлэн цэгцлүүлж байгууллагын архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулах, баримт бичгийн архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийг жил бүр хийж, данс бүртгэлийг хөтлөх;	Данс бүртгэлийг хөтлөн бүртгэл хийгдсэн байна.	Г
	4. Ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ олж мэдсэн улсын болон байгууллагын нууц, бусад ажилтнуудын хувийн нууцад	Мэдээллийг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлал,	Г,Т

	хамаарах асуудлыг задруулахгүй байх, хадгалах, хамгаалах;	аюулгүй байдлыг хангасан байна.	
	5.Архивын баримтад тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах ажлыг зохион байгуулах;	Байгууллагын архивын үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомж, стандарт, заавар журмын дагуу явагдсан байна.	Г,Х
	6.Байгууллагын архивын дотоод ажлын хэрэгцээнд ашиглуулахаар олгосон баримтын бүртгэл үйлдэх;	Бүртгэл хөтлөгдсөн байна.	Г
	7.Байгууллагын архивын лавлагаа, архивт хадгалагдаж байгаа баримтын хуулбарт "Хуулбар үнэн" дарж, үйлчлэх, бүртгэл үйлдэх;	Хуулбарыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон байна.	Г
	8.Архивт шаардлагатай техник хэрэгслийн талаар судалгаа, тооцоог гаргаж удирдлагад санал оруулах;	Шаардлагатай техник хэрэгслээр хангагдсан байна.	Г
	9.Баримтуудыг зориулалтын тавиур шүүгээнд холбогдох журам, стандартын дагуу байрлуулах;	Баримтын эмх цэгц сайжирсан байна.	Г
	10.Байгууллагын архивын ажлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Холбогдох байгууллагад тайлан, мэдээг хүргүүлсэн байна.	Г,Т
	1.Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, агуулахын эмх цэгц, ажлын байрны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээний чанарт хяналт тавьж, эвдэрч хэмхэрсэн тавилга эд хогшилыг засварлах ажлыг зохион байгуулах;	Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сайжирч, ажлын байрны тав тухтай орчин бүрдсэн байна.	Г,Х
	2.Албан хаагчдын хөрөнгө, материалын карт хөтлөлтийг тухай бүр баяжуулж, бүрэн бүтэн байдал, тоо ширхэг, хэмжээ, хэвийн ажиллагаа зэргийг шалгаж картанд гарын үсэг зурж баталгаажуулах;	Албан хаагчдын хөрөнгө, материалын картын баяжилт хийгдсэн байна.	
	3. Хөрөнгө, бараа материалын үлдэгдлийн тооллого хийх, тооцоо бодоход биеэр оролцож, чанар байдлаа алдсан хөрөнгө, бараа материалыг актлуулж данснаас хасах санал оруулж, холбогдох шийдвэр зөвшөөрлийн дагуу данснаас хасалт хийх;	Ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгө, бараа материал актлагдсан байна.	Г,Х
3 дугаар зорилтын хүрээнд	4. Байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай бараа материалын хангалт, олголтыг батлагдсан төсөвт багтаан хийж, зарцуулалтад хяналт тавих;	Шаардлагатай бараа материалын хангалтыг батлагдсан төсөвт багтаан хийсэн байна.	Т,Г
	5. Албан томилолтоор болон төлөвлөгөөт шинжилгээний ажлаар явах ажилтан нарт төвийн даргын зөвшөөрлөөр олгосон шатахууны талон зарцуулалт, хэрэглээнд хяналт тавьж ажиллах;	Шатахуун зарцуулалтын норм хэрэгжсэн байна.	Г
	6. Цаг уур орчны шинжилгээний газар болон бусад байгууллагаас хандив тусламж, хангалтаар ирсэн хөрөнгө, бараа материалыг өөрийн биеэр шалган хүлээн авч чанар, тоо бүртгэлийг тулгасны дараа холбогдох албан хаагчдад зохих маягтын дагуу шилжүүлэх;	Холбогдох маягтууд хөтлөгдөж гарын үсгээр баталгаажсан байна.	Г

4 дүгээр зорилтын хүрээнд	1. Анхан шатны бүртгэл хөтлөлтийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу хөтлөх;	Стандарт болон бодлогын баримт бичгийг мөрдсөн байна.	Г
	2. Хөрөнгө, бараа материалын олголтыг зохих маягтын дагуу төвийн даргын зөвшөөрлөөр хийж гүйцэтгэх;	Холбогдох маягт хөтлөгдөн гарын үсгээр баталгаажсан байна.	Г,Т
	3. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны тайланг нярвын санхүүгийн программаар мэдээг тогтоосон хугацаанд гаргаж тайлагнах;	Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, программыг бүрэн ашигласан байна.	Г,Т
5 дугаар зорилтын хүрээнд	1. Шууд удирдлага болон байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, ажлын хэсэгт ажиллах, үр дүнг тайлагнах; шаардлагатай мэдээллээр хангах;	Өгсөн үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэж, тайлагнасан байна. Ажлын хэсэгт идэвх, санаачилгатай ажилласан байна.	Г
	2. Эд хөрөнгө, бараа материал, байгууллагын архивтай холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргах, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, шаардлага тавьж хэрэгжилтэд нь хяналт тавих;	Стандарт хэрэгжсэн байна.	Х,Г
	3. Ажилдаа шинэ арга зүй, техник технологийг турших, нэвтрүүлэх талаар санал гаргах;	Санал боловсруулж өгсөн байна.	Г
	4. Хариуцсан ажилтай холбоотой мэдээ, тайлан, дүгнэлт, судалгааг холбогдох албан тушаалтан болон байгууллагад гаргаж өгөх;	Хугацаанд нь гарган өгч, хамтарч ажилласан байна.	Г
	5. Баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн журам, стандартын дагуу (хос бичгээр баримт хөтлөх) боловсруулах, өмнөх оны шийдвэрлэгдсэн баримтаар хэрэг бүрдүүлж хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж, дараа оны 1-р улиралд багтаан хадгаламжийн нэгж үүсгэн архивлах;	Баримт бичгийг холбогдох журам, стандартын дагуу боловсруулж бүрдүүлсэн байна. Архивт хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн байна.	Г
	6. Хариуцсан ажлын чиглэлээр иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хариу өгөх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	7. Монгол Улсын стандарт "Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага"-ыг үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх;	Стандартыг мөрдсөн байна.	Г
	8. Байгууллагын дэвшүүлсэн зорилтын хүрээнд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах, үнэлүүлэх;	Холбогдох журам, стандартыг хэрэгжүүлсэн байна.	Г
	9. Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйл, орчны ноцтой бохирдол үүссэн тохиолдоход тусгай горимд шилжин ажиллах;	Шаардлагатай тохиолдолд ажилласан байна.	Г,Т
	10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийг мөрдсөн байна.	Г

11.Хариуцсан ажлын чиглэлээр захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл лавлагааны баримт бичгийн төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
12.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд байгууллагын даргын зөвшөөрснөөр бусад байгууллага, иргэдтэй байгууллагыг төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
13. Хариуцсан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлыг зохистой ашиглах, бүрэн бүтэн байдлыг хангах;	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г
14. Эрхэлсэн ажилтай холбоотой хууль тогтоомж болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх;	Хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна.	Г
15.Байгууллагын бусад албан хаагчидтай ажлаа уялдуулан зохицуулах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах.	Бусад салбартай ажлаа уялдуулж хамтын ажиллагааг хэрэгжүүлсэн байна.	Т, Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	Нягтлан бодох бүртгэл (041101), Санхүү, банк даатгал (0412), Эдийн засаг (0311), хүрээлэн буй орчны шинжлэх ухаан (0521), уур амьсгал судлал (053212), ус судлал (053211), цаг уур судлал (053210), архив судлал (032202), бусад	
Мэргэшил	Архив, бичиг хэргийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;	
Түршлага		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон харьцуулсан шинжилгээ хийх, судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын үр дагаварыг харьцуулан үнэлэх; - шинэ санал санаачилга, бүтээлч хандлагатай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;
	Асуудал шийдвэрлэх	- Асуудлын учир шалтгааныг зөв тодорхойлж, шийдвэрлэх оновчтой хувилбарыг тогтоох; - Чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид нийцсэн, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; - Хууль тогтоомж, дүрэм, журмыг даган мөрдөж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
	Багаар ажиллах	- Төрийн албаны ёс зүйг баримтлах; - Хариуцлагатай, санаачилгатай, нээлттэй байж эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Багт өөрийн гүйцэтгэх үүргээ тодорхойлж, хариуцлагатай, хамтрагч байх;
	Бусад	- Өөрийн санал, бодлыг бусдад ойлгомжтой илэрхийлэх. - Компьютерийн хэрэглээний болон хариуцсан ажлын чиглэлээр ашиглагдаж байгаа программ, техник хэрэгсэл (принтер, сканнер, ухаалаг самбар, таблет, видео камер г.м)-ийг бүрэн эзэмшсэн байх; - Төрийн албан хэрэг хөтлөлт, монгол бичиг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - Англи хэлний анхан болон түүнээс дээш шатны мэдлэгтэй байх; - Орлон хөрвөн ажиллах чадвартай байх; - Цахим орчин, мэдээллийн систем ашиглах чадвартай байх; - Ажлын цаг баримтлах, үр бүтээлтэй ашиглах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шүүд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Ерөнхий нягтлан бодогч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
Үгүй	1. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллага, хэлтсүүд, холбогдох мэргэжилтэн 2. Байгууллагын нийт удирдах, гүйцэтгэх, туслах ажилтан, албан хаагчид 3. Төрийн бусад байгууллага, тэдгээрийн холбогдох мэргэжилтэн 4. Иргэн, хуулийн этгээд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ <i>Д. ГАНТУУЛ</i>	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: Байгууллагын нэр: АРХАНГАЙ АЙМГИЙН УС-ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ Шийдвэрийн огноо: 2025.11.17 Дугаар: А.148 ДАРГА: Б. ВУЛГАН БААТАР 2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр	

Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний
төвийн даргын 2025 оны 11 дугаар сарын 17-ны
өдрийн 1/18 дугаар тушаалын 19 дүгээр хэвсрэлт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:
☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

"Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025 оны 09 дүгээр сарын 19

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025 оны 11 дүгээр сарын 17

Байгууллагын нэр:

Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв

Албан тушаалын нэр:

Цаг агаарт зориудаар нөлөөлөх техникч-жолооч

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжлийн, ТҮМ-3

Ажлын байрны албан ёсны байршил:

Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 7-р баг, Хөгжлийн гудамж 105 тоот

Онцгой нөхцөл:

Албан томилолтоор ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны тасралтгүй бэлэн байдлыг хангах, автомашины ашиглалт, бүрэн бүтэн, бэлэн байдлыг хариуцаж, гүйцэтгэлийн үр дүнг төвийн дарга болон ерөнхий нягтлан бодогчийн өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаанд хэрэглэгдэх харвах төхөөрөмж, борооны пуужингийн тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцаж, бэлтгэл ажлыг хангаж оролцох;
- Автомашинаар саадгүй үйлчлэх, хариуцаж байгаа автомашины засвар үйлчилгээ, бүрэн бүтэн байдлыг хангаж, шатахуун, сэлбэг хэрэгслийн тооцоо, тайланг тухай бүрд нь хийх;
- Байгууллагын аж ахуйн ажилд туслах чиг үүргүүдийг гүйцэтгэх;
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
--------	------------------------------------	-------------------------------	--

1 дүгээр зорилтын хүрээнд	1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх;	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна.	Г,Х
	2. Үндсэний хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдэд хариуцсан ажлын чиглэлээр санал оруулах болон хэрэгжилтийг хангаж, тайлагнах;	Хэрэгжилтийг тайлагнасан байна.	Г,Х
	3. Дүрс бичлэг хийх хянагч бөгөөд бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангаж ажиллахаас эхлээд синоптик процессын хэлэлцүүлэг, газарзүйн байршил, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, үзлэг үйлчилгээ хийж буй байдал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн байдал, харвалтын байдлыг дэс дарааллаар бичиж баталгаажуулах;	Харвах үйл ажиллагааны процессыг дарааллын дагуу бичиж баталгаажуулсан байна.	Г,Т
	4.Харвах төхөөрөмж, борооны пуужингийн тээвэрлэлтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцаж, ачих, буулгах, хураах, угсрах ажлыг хийж гүйцэтгэх;	Харвах төхөөрөмж болон борооны пуужингийн тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангасан байна.	Г
	5.Цаг агаарт зориудаар нөлөөлөх (экспедиц)-ийн ерөнхий инженерийн заавраар харвах төхөөрөмжийн тэжээлийг залгаж, салгах;	Аюулгүй ажиллагааны зааврыг мөрдсөн байна.	Г
	6.Харвалт хийх газраас пуужингийн хөөрөлтийн замналын замын маршрутын дагуу 3-5 км эргэн тойронд орчны аюулгүй байдлыг хянаж, баталгаажуулах ажилд оролцож, тэмдэглэл хийх;	Аюулгүй байдлыг хянаж, тэмдэглэл хөтөлсөн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	7. Газрын хянагч хийх, пуужингийн ниссэн замналын дагуу харж, пуужингийн үлдэгдэл хаана, аль газар оронд унаж болохыг тооцож, эрэн хайх зам, чиглэлийг гаргах;	Пуужингийн үлдэгдлийг эрэн хайх, зам чиглэлийг гаргасан байна.	Г
	1.Автомашины бэлэн байдлыг хангаж, техникийн үзлэг, засвар, үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол хийж, грашийн эмх цэгцийг хариуцах;	Бэлэн байдлыг хангасан байна.	Г
	2. Автомашины эвдрэл гэмтлийг тухай бүр техникийн комиссын дүгнэлтээр баталгаажуулж, өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулах;	Эвдрэл гэмтлийг тухай бүр танилцуулж, шийдвэрлүүлсэн байна.	Г
	3.Аймаг, хот болон орон нутагт төлөвлөгөөт шинжилгээний ажилд явах чиглэл, маршрут, шаардагдах шатахуун, тослох материалын тооцоог гаргаж, төвийн даргаар баталгаажуулах;	Тухай бүр баталгаажуулсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	4.Жолоочийн замын тооцооны хуудас, шатахууны тооцоог гаргаж, санхүүд хүлээлгэн өгөх;	Журамд заасан хугацаанд хүлээлгэн өгч, тооцоо нийлсэн байна.	Г
	1. Шинээр авсан тавилга, хэрэгслийг угсарч байрлуулах ажилд оролцох;	Албан хаагчдын ажиллах орчныг бүрдүүлсэн байна.	Г,Т
	2.Их болон урсгал засварын үед шаардлагатай засвар, үйлчилгээг хийж гүйцэтгэх;	Засвар, үйлчилгээг хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.	Г,Т

	3.Арга хэмжээний чимэглэл, бэлтгэл ажилд оролцон туслах, байрны гадна талбайн цэвэрлэгээ, тохижилтын ажлыг гүйцэтгэх, зохион байгуулах;	Холбогдох үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэсэн байна.	Г,Т
	4. Галлагааны улиралд ээлжийн хуваарьт орж ажиллах, ээлжийг тогтмол хүлээлцэж холбогдох албан тушаалтанд танилцуулах;	Галлагааны хэвийн тасралтгүй ажиллагаа хангагдсан байна.	Т, Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Шууд удирдлага болон байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, ажлын хэсэгт ажиллах, үр дүнг тайлагнах, шаардлагатай мэдээллээр хангах;	Өгсөн үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэж, тайлагнасан байна. Ажлын хэсэгт идэвх, санаачилгатай ажилласан байна.	Г
	2. Байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцох;	Идэвхтэй оролцсон байна.	Г
	3.Баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн журам, стандартын дагуу (хос бичгээр баримт хөтлөх) боловсруулах,	Цаасан суурьтай болон цахим баримт бүрдүүлсэн байна.	Г
	4. Монгол Улсын стандарт "Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага"-ыг үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх;	Стандартыг мөрдсөн байна.	Г
	5.Байгууллагын дэвшүүлсэн зорилтын хүрээнд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах, үнэлүүлэх;	Холбогдох журам, стандартыг хэрэгжүүлсэн байна.	Г
	6.Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйл, орчны ноцтой бохирдол үүссэн тохиолдолд тусгай горимд шилжин ажиллах;	Шаардлагатай тохиолдолд ажилласан байна.	Г,Т
	7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуультогтоомжийг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийг мөрдсөн байна.	Г
	8. Хариуцсан эд хөрөнгө, техник хэрэгслийг ариг гамтай зориулалтын дагуу ашиглах, бүрэн бүтэн байдлыг хангах, ээлж өгөх, авахдаа бүртгэлээр заавал хүлээлцэж байх, гарсан зөрчлийн талаар шууд удирдлагад тухай бүр танилцуулах, автомашины техник ашиглалтын паспортыг тогтмол хөтөлж баталгаажуулах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	9.Хариуцсан ажилтай холбоотой мэдээ, тайлан, судалгааг холбогдох албан тушаалтан болон байгууллагад гаргаж өгөх, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	Хугацаанд гаргаж өгсөн байна.	Г, Х, Ш
	10. Эрхэлсэн ажилтай холбоотой хууль тогтоомж болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Техникийн болон түүнээс дээш боловсролтой байх.
Мэргэжил	Байгалийн шинжлэх ухаан (053), Цэрэг, батлан хамгаалах (1031), бусад
Мэргэшил	- Жолоочийн "B,D" ангилалтай байх; - Тэсэлгээний ажлыг гүйцэтгэх, тэсрэх материалтай харьцах үнэмлэхтэй байх; - Мэргэшсэн жолоочийн эрхтэй (үнэмлэхтэй).
Туршлага	Жолоочоор 3-аас доошгүй жил ажилласан байх.

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- шинэ санал санаачилга, бүтээлч хандлагатай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;
	Асуудал шийдвэрлэх	- Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх; - Тээврийн хэрэгслийн эвдрэлийг оношлох, засвар хийх, шаардлагатай сэлбэг хэрэгслийг солих;
	Багаар ажиллах	- Төрийн албаны ёс зүйг баримтлах; - Хариуцлагатай, санаачилгатай, нээлттэй байж эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Багт өөрийн гүйцэтгэх үүргээ тодорхойлж, хариуцлагатай, хамтрагч байх;
	Бусад	- Өөрийн санал, бодлыг бусдад ойлгомжтой илэрхийлэх; - Бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах - Компьютерийн хэрэглээний (word, excel, power point г.м) программыг хариуцсан ажлын чиглэлээр ашиглах чадвартай байх; - Төрийн албан хэрэг хөтлөлт, монгол бичиг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - Орлон хөрвөж ажиллах; - Орон нутгийн нөхцөлд авто тээврийн хэрэгслийн эд ангийн эвдрэл гэмтлийг оношлох, засварлах. - Цахим орчин, мэдээллийн систем ашиглах чадвартай байх; - Ажлын цаг баримтлах, үр бүтээлтэй ашиглах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шүүд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Ерөнхий нягтлан бодогч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Үгүй.

Бусад харилцах субъект:

1. Цаг уур, орчны шинжилгээний газрын холбогдох албан тушаалтан
2. Байгууллагын нийт удирдах, гүйцэтгэх, туслах ажилтан, албан хаагчид
3. Төрийн бусад байгууллага, тэдгээрийн холбогдох мэргэжилтэн
4. Иргэн, хуулийн этгээд


V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын боловсруулсан:	тодорхойлолтыг	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ	Д.ГАНТУУЛ	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр		
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:		
Байгууллагын нэр:		
АРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ		
Шийдвэрийн огноо: 2025. 11. 17		
Дугаар: 17/48		
ДАРГА: Б.БУЛГАНБААТАР		
2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр		

6003592 СТА3742 0122030032

---oOo---

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн 1/48 дугаар тушаалын 20 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ				
Албан	тушаалын	тодорхойлолтыг	боловсруулсан	үндэслэл:
☐	Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан			
☐	Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон			

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	"Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/162 дугаар тушаал
---	---

Дагаж мөрдөх огноо:	2025 оны 09 дүгээр сарын 19
---------------------	-----------------------------

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	2025 оны 11 дүгээр сарын 17
---	-----------------------------

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв	
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Сантехникийн слесарь	Төрийн үйлчилгээ, ТҮ-3
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ажлын өдрийн 8 цаг	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 7-р баг, Хөгжлийн гудамж 105 тоот
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ	
Албан тушаалын зорилго: Байгууллагын халаалт, сантехникийн системийн ашиглалт, засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэх, төвийн эд хөрөнгө, объектын бүрэн, бүтэн байдлыг хариуцаж, харуул хамгаалалтын үүргийг хариуцаж, гүйцэтгэлийн үр дүнг төвийн дарга болон ерөнхий нягтлан бодогчийн өмнө хариуцна.	
Албан тушаалын зорилт: 1. Байгууллагын халаалт, сантехникийн системийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн өдөр тутмын засвар үйлчилгээг явуулах, сантехникийн тоног төхөөрөмж, системийн ажиллагаанд өдөр тутам хяналт тавих, доголдлыг шуурхай арилгах; 2. Байгууллагын ажил, үйлчилгээг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, эд хөрөнгө, тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцах, сэлбэн засварлах; 3. Сантехник мужааны засвар үйлчилгээний төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх графикийг мөрдөж ажиллах; 4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах – Т, Хариуцан гүйцэтгэх – Г Хянах – Х
--------	------------------------------------	-------------------------------	--

			Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Сантехникийн системийг суурилуулах, ашиглалтыг хангах, засвар үйлчилгээг хийх, сантехникийн системийн эвдрэл, ослын үед засвар үйлчилгээг шуурхай хийх;	Байрны халаалт, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээ цаг хугацаандаа хийгдсэн байна.	Г
	2.Сантехникийн системийн байдлын талаарх мэдээллийг удирдлагадаа шуурхай мэдээлэх;	Холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр удирдлагад мэдээлсэн байна.	Г
	3. Крантнаас ус алдах, шугам цоорох үед цаг алдалгүй арга хэмжээ авах;	Хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	Г
	4.Дулааны болон сантехникийн тоног төхөөрөмж, шугам сүлжээний урсгал засвар үйлчилгээг тогтмол хийх, найдвартай ажиллагааг хангах;	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар зөрчигдөхгүй систем доголдолгүй хэвийн ажилласан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахад санаачилгатай ажиллах;	Эд хөрөнгө, тавилга хэрэгсэл бүрэн бүтэн байна.	Г
	2.Нийтийн эзэмшлийн талбай, өрөө тасалгаа, тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдалд тогтмол үзлэг шалгалт хийх, сэлбэн засварлах;	Тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавьж ажилласан байна.	Г
	3.Сэлбэн засварлах боломжгүй эд хөрөнгийн талаар холбогдох албан тушаалтанд танилцуулах;	Бодит мэдээ, мэдээллийг удирдлагад таницуулсан байна.	Г
	4. Шинээр авсан тавилга, хэрэгслийг угсарч байрлуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэх;	Албан хаагчдын ажиллах орчныг бүрдүүлсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Халаалтын улиралд төвийн галлагааг хариуцаж, цахилгаан зуухны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөх;	Аюулгүй ажиллагаа мөрдөгдсөн байна.	Г
	2. Байгууллагын харуул хамгаалалтын ажлыг тогтмол гүйцэтгэх;	Харуул хамгаалалтын ажлыг хариуцлагатай гүйцэтгэсэн байна.	Г
	3.Их болон урсгал засварын үед шаардлагатай засвар, үйлчилгээг хийж гүйцэтгэх;	Засвар, үйлчилгээг хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.	Г
	4.Арга хэмжээний чимэглэл, бэлтгэл ажилд оролцон туслах, байрны гадна талбайн цэвэрлэгээ, тохижилтын ажлыг гүйцэтгэх;	Холбогдох үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Шууд удирдлага болон байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах, шаардлагатай мэдээллээр хангах;	Өгсөн үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэж, тайлагнасан байна.	Г
	2. Байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцох;	Санаачилгатай ажилласан байна.	Г
	3. Монгол Улсын стандарт “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага”-ыг үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх;	Стандартыг мөрдсөн байна.	Г

	4. Байгууллагын дэвшүүлсэн зорилтын хүрээнд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Холбогдох журам, стандартыг хэрэгжүүлсэн байна.	Г
	5. Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйл, орчны ноцтой бохирдол үүссэн тохиолдоход тусгай горимд шилжин ажиллах;	Шаардлагатай тохиолдолд ажилласан байна.	Г
	6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийг мөрдсөн байна.	Г,Т
	7. Хариуцсан эд хөрөнгө, багаж хэрэгслийг ариг гамтай зориулалтын дагуу ашиглах, бүрэн бүтэн байдлыг хангах, ээлж өгөх, авахдаа бүртгэлээр заавал хүлээлцэж байх, гэмтэл саатаг гарсан тухай бүр гарсан зөрчлийн талаар шууд удирдлагад тухай бүр танилцуулах, шаардлагатай ажлыг гүйцэтгэх;	Холбогдох журам, стандартыг мөрдсөн байна. Ээлжийг хүлээлцэж холбогдох албан тушаалтанд танилцуулсан байна.	Х,Г
	8. Эрхэлсэн ажилтай холбоотой хууль тогтоомж болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна.	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Техникийн болон түүнээс дээш боловсролтой байх.	
Мэргэжил	Мэргэжлийн үнэмлэхтэй байх.	
Мэргэшил		
Туршлага		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- сантехникийн эвдрэл гэмтлийг оношлох чадвартай байх; - шинэ санал санаачилга, бүтээлч хандлагатай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;
	Асуудал шийдвэрлэх	- албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх;
	Багаар ажиллах	- Төрийн албаны ёс зүйг баримтлах; - Хариуцлагатай, санаачилгатай, нээлттэй байж эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Багт өөрийн гүйцэтгэх үүргээ тодорхойлж, хариуцлагатай, хамтрагч байх;
	Бусад	- Өөрийн санал, бодлыг бусдад ойлгомжтой илэрхийлэх; - Бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах. - Ажлын цаг баримтлах, үр бүтээлтэй ашиглах.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шүүд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Ерөнхий нягтлан бодогч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
Үгүй.	1. Байгууллагын нийт удирдах, гүйцэтгэх, туслах ажилтан, албан хаагчид 3. Төрийн бусад байгууллага, тэдгээрийн холбогдох мэргэжилтэн 4. Иргэн, хуулийн этгээд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ <i>Д.ГАНТУУЛ</i> 2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: АРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ Шийдвэрийн огноо: ... 2025.11.17 Дугаар: 148 ДАРГА: Б.БУЛГАНБААТАР 2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр	

---oOo---

Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний
төвийн даргын 2025 оны 11 дугаар сарын 17-ны
өдрийн А/48 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЭЛЭЛ				
Албан	тушаалын	тодорхойлолтыг	боловсруулсан	үндэслэл:
☐	Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан			
☐	Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон			

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: "Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/162 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо: 2025 оны 09 дүгээр сарын 19

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2025 оны 11 дүгээр сарын 17

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв	
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Үйлчлэгч	Төрийн үйлчилгээний албан тушаал ТҮ-1
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ажлын өдрийн 8 цаг	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 7-р баг, Хөгжлийн гудамж 105 тоот
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	Хамаарахгүй.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ	
Албан тушаалын зорилго: Байгууллагын өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэх, албан хаагчдын ажиллах цэвэр, тухтай орчныг бүрдүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг төвийн дарга болон ерөнхий нягтлан бодогчийн өмнө хариуцна.	
Албан тушаалын зорилт: 1. Төвийн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол, чанартай хийж гүйцэтгэх; 2. Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг мөрдөн ажиллах; 3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;	

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Хариуцсан талбай, өрөө тасалгааг зориулалтын материалаар өдөр тутам тогтмол цэвэрлэж, албан хаагчдын тав тухтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;	Чанартай гүйцэтгэсэн байна.	Г

	2. Гадна болон дотоод ариун цэврийн өрөөний хог хаягдлыг цэвэрлэх ажлыг гүйцэтгэх;	Чанартай гүйцэтгэсэн байна.	Г
	3.Тогтоосон хугацаанд хариуцсан талбайд их цэвэрлэгээ хийж гүйцэтгэх;	Улирал тутам гүйцэтгэсэн байна.	Г
	4. Цэвэрлэгээ гүйцэтгэхдээ албан хаагчийн өрөөний эд зүйлсийн эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хангах;	Ажиллах нөхцөл хангагдсан байна.	Г
	5.Байгууллагын гадна орчны тохижилт, эргэн тойрны хог хаягдал, цэвэрлэгээ үйлчилгээний ажлуудыг хариуцан гүйцэтгэх;	Холбогдох ажлыг зохион байгуулсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Цэвэрлэгээ үйлчилгээг хийхдээ ахуйн бээлий өмсөж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах;	Холбогдох журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Г
	2. Цэвэрлэгээнд ашиглагдах зориулалтын тоног төхөөрөмж, ариутгалын бодис зэргийг зааврын дагуу ашиглах;	Холбогдох журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Г
	3. Цэвэрлэгээний материал, харицсан эд хөрөнгө, багаж хэрэгслийг зориулалтын дагуу ариг гамтай ашиглах, бүрэн бүтэн байдлыг хангах;	Холбогдох журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Г
	4. Байгууллагын засвар үйлчилгээ, тохижилт, зохион байгуулах арга хэмжээний засал чимэглэл хийх ажилд оролцох.	Холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Шууд удирдлага болон байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах, шаардлагатай мэдээллээр хангах;	Өгсөн үүрэг даалгаврыг бүрэн гүйцэтгэж, тайлагнасан байна.	Г
	2. Монгол Улсын стандарт "Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага"-ыг үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх;	Стандартыг мөрдсөн байна.	Г
	3.Байгууллагын дэвшүүлсэн зорилтын хүрээнд тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Холбогдох журам, стандартыг хэрэгжүүлсэн байна.	Г
	4.Байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, давагдашгүй хүчин зүйл, орчны ноцтой бохирдол үүсэн тохиолдоход тусгай горимд шилжин ажиллах;	Шаардлагатай тохиолдолд ажилласан байна.	Г
	5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжийг мөрдсөн байна.	Г,Т
	6.Хариуцсан ажилтай холбоотой мэдээ, тайлан гаргах;	Тайлан, мэдээг гаргасан байна.	Г
	7. Эрхэлсэн ажилтай холбоотой хууль тогтоомж болон холбогдох байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн бус дунд болон түүнээс дээш боловсролтой.	
Мэргэжил		
Мэргэшил		
Туршлага		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- шинэ санал санаачилга, бүтээлч хандлагатай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;

	Асуудал шийдвэрлэх	- албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх;
	Багаар ажиллах	- Төрийн албаны ёс зүйг баримтлах; - Хариуцлагатай, санаачилгатай, нээлттэй байж эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Багт өөрийн гүйцэтгэх үүргээ тодорхойлж, хариуцлагатай, хамтрагч байх;
	Бусад	- Өөрийн санал, бодлыг бусдад ойлгомжтой илэрхийлэх; - Бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах. - Ажлын цаг баримтлах, үр бүтээлтэй ашиглах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Ерөнхий нягтлан бодогч

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-

Бусад харилцах субъект:

1. Байгууллагын нийт удирдах, гүйцэтгэх, туслах ажилтан, албан хаагчид
3. Төрийн бусад байгууллага, тэдгээрийн холбогдох мэргэжилтэн
4. Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ
ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Д.ГАНТУУЛ

Байгууллагын нэр:

Шийдвэрийн огноо:

Дугаар:

2023 оны 11 дугаар сарын 17-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

АРХАНГАЙ АЙМГИЙН УСЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Шийдвэрийн огноо: 2025. 11. 17

Дугаар:

ДАРГА:

Б.БУЛГАНБААТАР

2025 оны 11 дугаар сарын 17-ны өдөр



УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ



Web site:

<https://arkhangai.weather.gov.mn/>

<https://arkhangai.namem.gov.mn/>



Facebook page:

Архангай аймгийн Ус, цаг уур,
орчны шинжилгээний төв



Имэйл хаяг:

info@arkhangai.namem.gov.mn



Холбоо барих:

Утас ажил: 70332095

Хүний нөөц, бичиг хэргийн эрхлэгч Д.Гантуул

Холбоо барих утас: +976 88078301